



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 21 өдөр

Дугаар 4/528

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо шинэчлэн
байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Алтанбулаг сумын Мөнх-Өлзийт, Дорноговь аймгийн Сайхандулаан суман дахь радиолокаторын байгууламжуудын харуул, хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Х.Баттулга	Холбоо, навигаци, ажиглалтын албаны ерөнхий инженер
Нарийн бичгийн дарга:	Б.Санчир	Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Д.Отгонхүү	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Техникийн төлөвлөлт, инженерингийн хэсгийн лабораторийн инженер
	Д.Атарсайхан	Монголын аэронавигацийн инженер техникийн ажилтнуудын холбооны гишүүн
	М.Эрдэнэсүх	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Х.Баттулга/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Санчир/-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2018 оны А/495 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

